

СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТЭС

2025 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 16 удаа зохион байгуулж, 423 байгууллагын 6325 тамирчдыг оролцуулж нийт улс, нийслэлийн төсвөөс 419,072,000 төгрөгийг зарцуулсан.

Нийслэл дүүргийн хэмжээнд хагас жилийн байдлаар спортын уралдаан тэмцээнийг 122 удаа зохион байгуулж 10919 байгууллагын 187161 тамирчдыг оролцуулж нийт улсын төсвөөс 150,493,100 төгрөг, нийслэлийн төсвөөс 929,709,000 төгрөг, бусад 35,957,900 төгрөгийг зарцуулсан.

ӨВЛИЙН СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

Өвлийн улиралд иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр 20 удаагийн биеийн тамир, спортын арга хэмжээ, 27 байршилд мөсөн гулгуурын талбай, цанын баазыг байгуулж, биеийн тамир, спортын үйлчилгээг нийт 389,559 иргэдэд хүргэж ажилласан. Үүнд:

Нийслэлийн 9 дүүрэгт нийтийг хамарсан 10 арга хэмжээ зохион байгуулж 26,709 иргэнийг хамруулсан.

Өвлийн спортын төрлөөр Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнийг 7 удаа зохион байгуулж 693 тамирчин оролцсон.

Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт өвлийн спортын 3 төрөл (хоккей, тэшүүр, шорттрейк)-ийн төрлөөр 95 хүүхэд, багачууд секц, дугуйланд хамрагдаж байна.

Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 06 дугаар сарын 10-ны хооронд 103,062 иргэн үйлчлүүлсэн байна.

Сүхбаатар, Баянзүрх, Багануур дүүрэгт Хандгайт, Скай ресорт, Галуут тур, Улаанбаатар цанын баазуудад 153,000 иргэн үйлчлүүлсэн байна.

Орон сууц, гэр хорооллын 22 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдаж 106,000 иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.

НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ МӨСӨН ШАГАЙН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын 2025 оны аварга шалгаруулах мөсөн шагайн тэмцээнийг 2025 оны 01 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд Монголын үндэсний мөсний шагайн холбоотой хамтран зохион байгуулж 9 дүүргийн 12 байгууллагын 100 тамирчид оролцсон. Нийслэлийн төсвөөс 5,090,000 төгрөгийг зарцуулсан.

НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭШҮҮРИЙН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын 2025 оны аварга шалгаруулах тэшүүрийн тэмцээнийг 2025 оны 01 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Монголын тэшүүрийн холбоотой хамтран зохион байгуулж, 6 байгууллагын 102 тамирчид оролцсон. Нийслэлийн төсвөөс 6,800,000 төгрөгийг зарцуулсан.



**НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН
УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ШОРТ РЕКИЙН ТЭМЦЭЭН**

Улаанбаатар хотын 2025 оны аварга шалгаруулах шорт рекийн тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Монголын тэшүүрийн холбоотой хамтран зохион байгуулж, 10 байгууллагын 55 тамирчид оролцсон. Нийслэлийн төсвөөс 5,940,000 төгрөгийг зарцуулсан.

**НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН
УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ВИРТУАЛ ДУГУЙН ТЭМЦЭЭН**

Улаанбаатар хотын аварга шалгаруулах Виртуал дугуйн тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Монголын дугуйн холбоотой хамтран зохион байгуулж, 12 насны ангиллаар 59 тамирчид оролцсон. Нийслэлийн төсвөөс 9,400,000 төгрөгийг зарцуулсан.

**НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН
УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
МӨСӨН СУРЫН ХАРВААНЫ ТЭМЦЭЭН**

Нийслэлийн Өвлийн спортын наадмын Улаанбаатар хотын аварга шалгаруулах Тэшүүрийн тэмцээнийг 2024 оны 02 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Монголын мөсөн сурын холбоотой хамтран зохион байгуулж 15 байгууллагын 150 тамирчин оролцсон. Нийслэлийн төсвөөс 4,620,000 төгрөгийг зарцуулсан.

**НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН
УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
СНӨҮБОАРДЫН ТЭМЦЭЭН**

Улаанбаатар хотын 2025 оны аварга шалгаруулах снөүбоардын тэмцээнийг 2025 оны 01 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Монголын мэргэжлийн снөүбоардын холбоотой хамтран зохион байгуулж, 10 байгууллагын 63 тамирчид оролцсон. Нийслэлийн төсвөөс 4,700,000 төгрөгийг зарцуулсан.

**НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН
УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТУЯЛЗУУР СЭЛЭМНИЙ ТЭМЦЭЭН**

Улаанбаатар хотын 2025 оны аварга шалгаруулах тэшүүрийн тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Монголын туялзуур сэлэмний холбоотой хамтран зохион байгуулж, 5 байгууллагын 120 тамирчид оролцсон.

**УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ЗУУН БУУДАЛТ ДААМНЫ ТЭМЦЭЭН**

Цаглашгүй Монгол ухаан ТББ хамтран Улаанбаатар хотын 2025 оны аварга шалгаруулах өсвөр үеийн зуун буудалт даамны тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн спорт зааланд зохион байгуулж, 9 байгууллагын 190 тамирчид оролцож, улсын төсвөөс 2,480,000 төгрөгийг зарцуулсан.



УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ ТЭМЦЭЭН

Монголын Ширээний теннисний холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах Ширээний теннисний тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Ширээний теннисний Оч клубт зохион байгуулж, 30 байгууллагын 210 тамирчид оролцож, улсын төсвөөс 5,640,000 төгрөгийг зарцуулсан.



УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ӨСВӨР ҮЕИЙН ЖҮДО БӨХИЙН ТЭМЦЭЭН

Монголын Жүдо бөхийн холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах өсвөр үеийн Жүдо бөхийн тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 07-09-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулж 30 байгууллагын 1560 тамирчид оролцож, улсын төсвөөс 7,320,000 төгрөг зарцуулсан.

УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ СПОРТЫН ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭН

Монголын Гимнастикийн холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах өсвөр үеийн Спортын гимнастикийн тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Монголын гимнастикийн холбооны спорт цогцолборт зохион байгуулж, 10 байгууллагын 150 тамирчид оролцож улсын төсвөөс 6,240,000 төгрөгийг зарцуулсан.



УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ХОНХОТ БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын Хонхот бөмбөгийн холбоотой хамтран Улаанбаатар хотын 2024 оны аварга шалгаруулах Хонхот бөмбөгийн тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулж, 10 байгууллагын 50 тамирчид оролцож, улсын төсвөөс 3,060,000 төгрөгийг зарцуулсан.



УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ҮНДЭСНИЙ СУРЫН ТЭМЦЭЭН

Монголын Үндэсний сурын харвааны холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах Үндэсний сурын тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд үндэсний сурын талбайд зохион байгуулж 47 байгууллагын 361 тамирчид оролцож, улсын төсвөөс 4,200,000 төгрөгийг зарцуулсан.

ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ “ХАНГАРДИ” НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/489 дүгээр захирамжаар Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын ширээний теннисний холбоотой хамтран Олон улсын ширээний теннисний өдөрт зориулсан “Хангарди” ширээний теннисний тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд төв асарт зохион байгуулсан.

Арга хэмжээнд нийт 30 байгууллагын 1500 иргэд, тамирчид оролцсон байна.



“ХАНГАРДИ” ҮНДЭСНИЙ ШАГАЙН ХАРВААНЫ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/489 дүгээр захирамжаар Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын үндэсний шагайн харвааны холбоотой хамтран Үндэсний шагайн харвааны тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд төв асарт зохион байгуулсан.

Арга хэмжээнд нийт 179 байгууллагын 1500 иргэд, тамирчид оролцсон.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЕБС-ИЙН СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ” САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/723 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, хамтран 2024 оны 12 дугаар сарын 01-нээс 2025 оны 03 дугаар сарын 18-ны хооронд 3 насны ангиллаар, 5 үе шаттай амжилттай зохион байгуулсан.

Бага, дунд, ахлах насны ангиллаар нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 192 сургуулийн охид, хөвгүүдийн 8208 багийн 90550 мянга гаруй сурагч оролцсон.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ” ВОЛЕЙБОЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” волейболын тэмцээнийг 2024 оны 12 дугаар сарын 01-нээс 2025 оны 04 дүгээр сарын 23-ний хооронд 2 насны ангиллаар, 3 үе шаттай зохион байгуулж 9 дүүргийн ерөнхий боловсролын 141 сургуулийн охид, хөвгүүдийн 540 багийн 67120 мянга сурагч оролцсон бол нийслэлийн шигшээ тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд нийслэлийн шатанд дунд, ахлах насны шилдэг нийт 42 сургуулийн 64 багийн 832 тамирчид өрсөлдсөн.



ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГИЙН

Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх, биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 28 төрөлд 95 багт 95 дасгалжуулагчтай 3150 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулж байна.

Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2025 оны хагас жилд тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит 302 удаагийн тэмцээнд оролцож 1311 медаль авсан амжилт үзүүлсэн бол Баянзүрх, Баянзүрх, Хан-Уул, Багануур, Багахангай, Налайх дүүрэг өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж 217,447,500 төгрөгийг зарцуулсан байна.

СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТЭС